

ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

1. Зөвлөх ажлын зорилго: Зөвлөхийн ажлаар тухайн объектыг 2024 оноос ашиглалтын 5 жилийн хугацаанд хэвийн ашиглах төсөл, зөвлөмж боловсруулах.
2. Зөвлөх ажлын тайланд дараах зүйлс багтсан байна. Үүнд:
 - 2.1. Гидротехникийн байгууламжийн байдлын үнэлгээ
 - 2.2. Гарсан аваар, саатал, хүндрэлд хийсэн судалгаа, үнэлгээ.
 - 2.3. Тухайн гидротехникийн байгууламж дээр хийгдсэн судалгаа, технологийн ажил, түүний гүйцэтгэл.
 - 2.4. Хаягдлын аж ахуйн хэвийн ажиллагааг хангахтай холбоотой 2024-2029 оны үйлдвэрлэлийн технологийн үндсэн параметруудыг тодорхойлох
 - 2.5. Хаягдлын булингын гидротээвэрлэлтийн систем, хаягдлын гранулометрик бүрэлдэхүүн, булингын нягт г.м. хаягдлын аж ахуй дахь нийт цугларсан хаягдлын бүрэлдэхүүн, хэмжээ.
 - 2.6. Хаягдлыг хадгалах байгууламж: 2024 оноос 2029 он хүртэлх ашиглалтын үе дэх далан, хаялга ба тунгаах нуурын үзүүлэлт.
 - 2.7. Өвлийн болон зуны улирлын хугацаанд хаягдлыг хаях байрлал болон хаягдлын сангийн дүүргэлтийг оноор гаргах
 - 2.8. Хаягдлын аж ахуйн нуурын усны баланс.
 - 2.9. Эргэлтийн усан хангамжийн систем.
 - 2.10. Үзүүлэлт: булинга, эргэлтийн ус болон шүүх сувгийн дренажийн усны анализ.
 - 2.11. Хаягдлын санд хийгдэх ажлын зорилго, төрөл, хэмжээ, хэрэгжүүлэх график, шаардлагатай хөрөнгийн тооцоо.
3. Байгууламжуудын хяналтын үзүүлэлтүүд болон мониторинг.
4. Байгаль орчны хамгаалал.
5. Онцгой, аварийн нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, температурын горим .
6. 2024-2029 онуудын төслийн болон барилга ажлын график, хэмжээ, төсөв
7. Дүгнэлт
8. Хаягдлын аж ахуйг 2024-2029 оны хугацаанд ашиглах төсөл, зөвлөмж” боловсруулахад гүйцэтгэгчид дараах өгөгдлийг гаргаж өгнө:
 - 8.1. Баяжуулах фабрикийн үйлдвэрлэлийн үзүүлэлт: 2020, 2021, 2022, 2023, 2024 оноор.
 - Хүдэр боловсруулалт
 - Хаягдлын гарц
 - Баяжуулах фабрикийн жигд ажиллагааны коэф.
 - Баяжуулах фабрикийн жилийн ажлын өдрийн тоо
 - 1 тн хаягдал ноогдох технологийн усны зарцуулалт
 - Хаягдлын бүтэц, найрлага, гранулометрик бүрэлдэхүүн
 - Хаягдлын хувийн жин
 - 8.2. 2024 оны 1-р сарын байдлаарх хаягдлын сангийн план зураг (хаялга болон нуурын талбай, хаялгын хөндлөн огтлолууд, нууран дахь гүний хэмжилт, сүүлийн 5 жилийн түвшингийн хэмжилтийн дүн).
 - 8.3. 2019-2023 оны гидротээврийн системийн үзүүлэлт.
 - 8.4. Булинга тээвэрлэх шугамын хоолойн элэгдлийн байдал, эргэлтийн усны системийн байдал, шугамын дагуух өндөршлийн хэмжилт.
 - 8.5. Пьезометрийн байршил, түүн дэх усны түвшингийн 2019-2023 оны үзүүлэлт.

- 8.6. 2019-2023 онуудад хаягдлын аж ахуй дээр хийгдсэн ажил, байгуулсан барилга, байгууламжийн байршил, зураг, зорилго, гарсан үр дүн.
 - 8.7. Хаягдлын аж ахуйн холбоотой хийгдсэн судалгаа шинжилгээ, зөвлөмж, хяналтын ажлын тайлан, протокол болон бусад баримт бичиг.
 - 8.8. Хаягдлын аж ахуй болон эргэлтийн усан хангамжийн хэсэгт ажиллагсдын бүрэлдэхүүн .
9. Тухайн техникийн даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын тайлан, төсөл, зөвлөмжийг “Монголросцветмет” ХХК-ийн Техникийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээж авна..